



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ! №215 /424/ 2022.11.30

Тусгай дугаар



## НИЙГЭМ ХҮМҮҮНЛЭГИЙН ТЭНХИМ БАЙГУУЛАГДСАНЫ 55 ЖИЛ, ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ЦЭРГИЙН УЛС ТӨРИЙН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭЖ ЭХЭЛСНИЙ 50 ЖИЛИЙН ОЙД



### Мэндчилгээ



2022 онд тохиож буй ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхим үүсэн байгуулагдсаны 55 жил, Дээд боловсролтой улс төрийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 50 жилийн түүхт ойт тохиолдлууд үе үеийн цэргийн улс төрийн ажилтнууд, бэлтгэл болон чөлөөнд байгаа эрхэм генерал, офицер, эрдэмтэн багш нар, нийт төгсөгчиддөө гал цогтой баярын мэнд дэвшүүлжээ.

Анх Цэргийн бүх Ерөнхий сургуулийн бүтэцэд 1923-1924 оны хичээлийн жилээс эхлэн, 9 сарын хугацаатай Намын анги (сургууль)-ийг байгуулсан бөгөөд 1931 оноос ЦЕС-ийн "Цэргийн улс төрийн сургууль" болгон өргөтгөн бэхжүүлж, үндсэн болон түр, давтан сургалтаар дунд боловсролтой мянга орчим цэргийн улс төрийн ажилтныг сурган бэлтгэсэн түүхтэй.

БНМАУ-ын АЦХЭЯ-ны сайд бөгөөд Ардын армийн командлагч, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн 1967 оны 6-р сарын 12-ны өдрийн тушаалаар Марксизм-Ленинизмын кафедр (өнөөгийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхим)-ийг шинэчлэн байгуулсан төдийгүй 1972-1994 онд ЦЕДС, ЦНДС, ЦИС-ийн Улс төрийн ангийн 20 удаагийн төгсөлтөөр дээд боловсролтой цэргийн улс төрийн ажилтан-офицер, социологич (1992-1997 онд МУИС-ийн эрх зүйч, улс төр судлаач, философич) мэргэжлээр нийт 500 орчим төгсөгчид төрөн гарч, төр, засаг, батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин болон улс орны бүтээн байгуулалт, соёл боловсрол, шинжлэх ухаан, хувийн хэвшил, бизнесийн салбарын хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулаар ирсэн билээ.

XII зуунд дээд боловсролтой цэргийн улс төрийн ажилтны мэргэжил боловсрол, үүрэг оролцоо нь нийгэм, оюун санааны шинэ чиг хандлага, бүтээлч сэтгэлгээнд тулгуурлан өргөжин тэлж, залуу хойч үеийнхний манлайлал, сэтгэл зүй, ёс зүйн хөгжил төлөвшилийг хангах, соён гэгээрүүлэх, эх оронч үзэл, бахархлыг төлөвшүүлэх хэрэгт урьдын адил тэргүүлэгч, хүндтэй байр суурь эзлэх нь дамжиггүй юм.

Түүхт ойт тохиолдлуудан Нийгэм хүмүүнлэгийн тэнхимийн хамт олноос үе үеийн багш, төгсөгчдийн залгамж холбоог бэхжүүлэх, тэдний амжилт бүтээлийг алдаршуулах, сурталчлан таниулах үйлсэд бүтээлч санал санаачлага гарган, хамтран ажиллаж буй Та бүхэндээ дахин талархал дэвшүүлж, шинэ зууны соён гэгээрүүлэх ажил үйлсэд тань амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

НХТ-ийн ДАРГА

ДОКТОР, ДЭД ПРОФЕССОР И.ЧИНБАТ

### СУРГАЛТ: ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР

"ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА" бакалаврын сургалтын хөтөлбөрийн гол зорилго нь олон улсын улс төр, эдийн засаг, эрх зүй, аюулгүй байдал, цэрэг, батлан хамгаалахын харилцааны чиглэлээр мэргэшсэн, гадаад хэлний өндөр мэдлэгтэй, дипломат үйл ажиллагааны дадал, чадвартай олон улсын харилцаа, цэргийн атташегийн албан тушаал эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, чадамж эзэмшсэн, офицер, ажилтныг бэлтгэхэд оршино.

### "Олон улсын харилцаа" бакалаврын сургалтын хөтөлбөрөөр төгсөгчид /2021-2022/

2021 23  
2022 19

### Дээд боловсролтой цэргийн улс төрийн мэргэжлээр төгсөгчдийн судалгаа /1976-1996 он/

1976	20
1977	30
1978	31
1979	24
1980	31
1981	26
1982	33
1983	32
1984	33
1985	25
1986	26
1987	27
1988	29
1989	26
1990	29
1991	18
1992	20
1993	12
1994	9
1997	16 /ЦИС, МУИС/

1921-1972 онд нам, улс төрийн түр, давтан курс болон цэргийн улс төрийн дунд мэргэжлээр 1000 орчим, 1972-1997 онд дээд боловсролтой цэргийн улс төрийн мэргэжлээр 497, нийт 1500 орчим төгсөгчдийг сурган бэлтгэжээ.



ЭРДМИЙН ХАМТ ОЛОН

### ЭРХЭМ ЗОРИЛГО

"Монгол Улсын Боловсролын болон Дээд боловсролын тухай хууль, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний шинэчлэлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, ерөнхий болон мэргэжлийн суурь хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж "НИЙГЭМ ХҮМҮҮНЛЭГ, СЭТГЭЛЭЭНИЙ МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ЧАДАМЖ, ХАНДАГА" бүхий чадварлаг хүний нөөцийг сурган бэлтгэхэд оршино"

### ТҮҮХЭН ТОВЧООН

/бүтэц, зохион байгуулалт/



### ОЙ УГТСАН БҮТЭЭЛЧ АЖЛУУД



Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн анхны уулзалт. 2022.04.06.

ҮБХИС-ийн захирлын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн "Ой тэмдэглэн өнгөрүүлэх тухай" А/110 дугаар тушаалаар Нийгэм хүмүүнлэгийн тэнхим үүсэн байгуулагдсаны 55 жил, дээд боловсролтой улс төрийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 50 жилийн ойт 2022 оны 6 дугаар сарын 12-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэж, ойг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлж байна.



Онол практикийн бага хурал - 2022.05.12.

### Дээд боловсролтой "улс төрийн ажилтан-офицер" мэргэжлийн анхны төгсөлт - бидний бахархал



Улс төрийн ангийн анхны төгсөгчдөд хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаа. 2022.06.12.



## НИЙГЭМ ХҮМҮҮНЛЭГИЙН ТЭНХИМ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 55 ЖИЛ, ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ УЛС ТӨРИЙН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭЖ ЭХЭЛСНИЙ 50 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ!



Өнөөдөр ҮБХИС-ийн Нийгэм Хүмүүнлэгийн тэнхим үүсэн байгуулагдсаны 55 жил, дээд боловсролтой улс төрийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 50 жилийн ойд зориулсан баярын хурал ёслол төгөлдөр болж байна.

Уг хуралд тус тэнхимийн 1989 оны төгсөгч, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо, Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд доктор, профессор Р.Болд, ҮБХИС-ын захирал бригадын генерал П.Жаргалан, НХТ-ийн дарга доктор дэд профессор И.Чинбат болон тус тэнхимийн үе, үеийн төгсөгчид, генерал, офицер, ахлагч, ажилтан, алба хаагчид, ахмадуудын төлөөлөл оролцож байна.



Энэ үеэр Ерөнхийлөгчийн аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо тус тэнхимийн 1989 оны төгсөгч Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн илгээлтэйг нийт хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчдөд уншиж танилцууллаа.

Үргэлжлүүлэн мөн 1989 оны төгсөгч Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр түүхт ойгоо тэмдэглэж буй төрөлх тэнхимийнхээ хамт олонд баяр хүргэж хэлсэн үг хэлсэн юм.



Мөн энэ үеэр эрхэлсэн ажилдаа он удаан жил үр бүтээлтэй ажиллаж амжилт гаргасан ажилтан, алба хаагчид, төгсөгчид, ахмадын төлөөллийг Батлан хамгаалах салбарын болон төрийн одон медалиар шагнаж урамшууллаа.

Ө.НАСАНТОГТОХ



# НИЙГЭМ ХҮМҮҮНЛЭГИЙН ТЭНХИМ БАЙГУУЛАГДСАНЫ 55 ЖИЛ, ДЭЭД БОЛОВСРОЛТОЙ ЦЭРГИЙН УЛС ТӨРИЙН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭЖ ЭХЭЛСНИЙ 50 ЖИЛИЙН ОЙД

## ОЙ УГТСАН БҮТЭЭЛЧ АЖЛУУД

Үгийг: СТА хурандаа Б.Отгонбаяр  
Хөгжмийг: СТА дэд хурандаа А.Ариунзаяа

### УЛС ТӨРИЙН РОТЫНХНЫ ДУУЛАЛ

Жанжин Сүхбаатарын алдрыг өргөсөн  
Журамт цэргийн суртлыг номлогчоос  
Шинэ цагийн түүхийг дархалсан  
Соён гэгээрүүлэгчдийн залгамж халаа  
Бид улс төрийн салбарын сонсогчид  
Бид улс төрийн ангийн оюутнууд  
Бадамлан дүрэлзэх одтойхон насны  
Бахархах үйл нь хиймортой явна  
Цэргийн хуаранд ижилдэн нөхөрлөсөн  
Цэл залуухан насны минь бахархал  
Жагсаалын дуутай он жилүүдийг үдсэн  
Сонсогч насны гэгээхэн дурсамжууд  
*Дахилт*  
Уянгат дууныхаа айзам эгшгээр  
Уриа дугаа эгнэгт цуурайтуулсан  
Дүрэмт хувцастай жигдрэн жагсаж  
Дуутай жагсаалд нэрээ мөнхөлсөн  
*Дахилт*

Ойд зориулан 1990 оны онц төгсөгч, МУСТА, яруу найрагч, хурандаа Б.Отгонбаярын шүлгээр Улс төрийн ангийн төгсөгчдийн сүлд дууг бүтээв. 2022.05.09.




Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" төслийн хүрээнд "ЦУСХАНЭ" ТББ болон НХТ-ийн багш, сонсогчид Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 35 мод суулгаж, эх дэлхийгээ баясгалаа. 2022.05.07.



• Ойг тохиолдуулан Монгол цэргийн музейн захирал, хурандаа Д.Ганзориг болон тус хамт олноос ахмад багш, доктор, дэд профессор Б.Дуламсүрэнд хүндэтгэл үзүүлэв.

• НХТ-ийн хамт олон "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэж, Монгол цэргийн орчинд мод тарив. 2022.05.24.



Ойг тохиолдуулан Улс төрийн ангийн 1990 оны төгсөгч, хурандаа Б.Болдбаатарын урилгаар "Эрдэнэт хот-2022" аялалыг зохион байгуулав. 2022.06.17-20.

## БИДНИЙ МАНЛАЙЛАЛ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүх



Монгол Улсын Ерөнхий сайд асан Р.Амаржаргал



ЗГ-ын гишүүн, БХ-ын сайд асан, УИХ-ын гишүүн Д.Бат-Эрдэнэ



Батлан хамгаалахын сайд Хурандаа генерал Ж.ЁНДОН



БНМАУ-ын прокурор, МAA-ийн Улс төрийн газрын дарга, Даслэгч генерал Д.ЁНДОНДУЙЧИР



МAA-ийн Улс төрийн газрын дарга /3 удаа/ Хошууч генерал Ж.ЦЭНД-АЮУШ



МУ-ын Ерөнхийлөгчийн АББХ-ын зөвлөх, дэслэгч генерал Ц.Тогоо



ЗГ-ын гишүүн, БХ-ын сайд Г.Сайханбаяр



УИХ-ын гишүүн асан, ШУГЗ, бэлтгэл хошууч генерал Н.Жалбажав



Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, доктор, профессор Р.Болд



Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан



Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, бригадын генерал Л.Алтангэрэл



БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга асан, бэлтгэл хурандаа Б.Батсайхан



ОБЕГ-ын тэргүүн дэд бөгөөд штабын дарга, бригадын генерал Ж.Чүлтэмсүрэн

## УЛААНХУАРАНГИЙН 10 МАРКСИСТ



Өвөр эгнээнд зүүн гар талаас Ж.Чадраабал, Б.Банзрагч, Л.Дамбийням, Б.Гова, Е.Моголцог, Арын эгнээнд зүүн гар талаас Т.Лувсандорж, Ш.Сандагсүрэн, С.Сандуйжав, Ч.Лувсандорж, Д.Даваадорж



Зүүн гар талаас Улс төрийн ротын захирагч, ахлах дэслэгч Г.Энхжаргал, ротын улс төрийн орлогч, дэслэгч Д.Лхагвадорж, курсын захирагч, ахмад Б.Ганбат, дэслэгч З.Уламбаяр, ахмад н.Нацагдорж, дэслэгч Ш.Буяндэлгэр нар /1984 он/

## Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ ЦАЛИНТ ОНЦ СУРЛАГАТАН ТӨГСӨГЧИД



Р.Болд /1977 оны төгсөгч/



М.Батхүү /1978 оны төгсөгч/



Д.Жаргалсайхан /1982 оны төгсөгч/



Г.Энхбаатар /1983 оны төгсөгч/



Д.Лхагвадорж /1984 оны төгсөгч/



Р.Лхагвасүрэн /1984 оны төгсөгч/



Б.Лхагваа /1984 оны төгсөгч/



С.Ганболд /1985 оны төгсөгч/



Б.Ганбат /1986 оны төгсөгч/



Л.Гантөмөр /1987 оны төгсөгч/



Л.Ариунжаргал /1988 оны төгсөгч/



Л.Энхтөр /1989 оны төгсөгч/

## БИДНИЙ БАХАРХАЛ



Тэнхимийн анхны дарга, доктор, профессор Л.Дамбийням



Монгол Улсын Ардын багш, шинжлэх ухааны доктор, профессор Г.Мягмаржав



Монгол Улсын Гавьяат багш, доктор, профессор, БХИС-ийн анхны Хүндэт доктор Б.Банзрагч



БХИС-ийн Хүндэт доктор, шинжлэх ухааны доктор, профессор Д.Гомбосүрэн



Монгол Улсын Гавьяат багш, доктор (Ph.D), профессор Б.Галиндэв



Монгол Улсын Гавьяат багш, УБХИС-ийн Хүндэт профессор А.Гэлэгжамц



УБХИС-ийн Хүндэт профессор, доктор, профессор С.Баатар



Багш, профессор Т.Хасгиа



Доктор, профессор Н.Ядмаа



Багш, дэд хурандаа Т.Доржнамжин



Багш, профессор Б.Болд



Доктор, профессор бэлтгэл хурандаа Ж.Энхбаяр



Багш, дэд профессор С.Орхон



Ахмад ажилтан Х.Энэбиш



Багш Ц.Төрбилэг



Багш, бэлтгэл хурандаа Ч.Алтангэрэл



Ахмад багш Х.Цогхүү



Доктор, профессор бэлтгэл хурандаа Ц.Дэмчигсүрэн



"ЦУТХАНЭ" ТББ-ын Тэргүүн, бэлтгэл хурандаа Б.Жуваа



"ЦУТХАНЭ" ТББ-ын Гүйцэтгэх захирал Н.Энхболд




"Шинэ Ази" группын захирал Л.Төрбаяр




Доктор, профессор, бэлтгэл хурандаа Г.Мягмарсамбуу



ЗХЖШ-ын ХМА-ны дарга, хурандаа Б.Отгонбаяр



ЦДБЭЧ-ын дарга, хурандаа Г.Золзаяа



УБХИС-ийн Хүндэт профессор, "Сэлэнгэпресс" ХХК-ны захирал М.Болд